

АЛТАЙ ДАМНАСАН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЯРИА ХЭЛЭЛЦЭЭ-ЖЕНДЭРИЙН ЭРХ
ТЭГШ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ЧУУЛГА УУЛЗАЛТАД

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ”

*УИХ-ын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга
П.Анужин*

Тогтвортой хөгжил, Жендэрийн эрх тэгш байдал чуулга уулзалтад оролцож буй хүндэт зочид, төлөөлөгчиддөө энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Дэлхийн улс орнууд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан “Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрт “Жендэрийн тэгш байдлыг хангах” зорилгыг дэвшүүлж, жендэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхээр үүрэг хүлээсэн.

Монгол Улсад жендэрийн тэгш байдлын үнэлгээ олон улсын дунджаас бага зэрэг дээгүүр байгаа хэдий ч 2010 онтой харьцуулахад буурсан байна. Дэлхийн эдийн засгийн форумын 2022 оны дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын дэлхийн дундаж үзүүлэлт 68.1% байсан бол Монгол Улс 71.5%-иар, **нийт 145 орноос 70 дугаарт**, Зүүн Ази, номхон далайн бүс нутагт 7 дугаар байранд орсон ба 2010 оны үзүүлэлт /71.9%/ -ээс 0,5 нэгжээр буурчээ. Үүнээс:

- Эрүүл мэнд ба амьд гарах боломж 98.0%-иар 1-р байранд,
- Эдийн засгийн оролцоо ба боломж 76.5%-иар 26-р байранд,
- Боловсрол эзэмшилт 99.4%-иар 63-р байранд,
- Улс төрийн эрх мэдэл 12.21%-иар 113-р байранд орсон. Парламент дахь эмэгтэйчүүд 17.1%-ийг эзэлж байгаа нь дэлхийн дунджаас 9,2% бага байна.

Монгол Улс жендэрийн үзэл баримтлалын хувьд дэвшилтэт улс билээ. Энэ хүрээнд эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдэд хөгжлийн тэгш боломж, сонголт бий болгоход чиглэсэн, Монголын нийгмийн онцлог, хөгжлийн өнөөгийн хэрэгцээнд илүүтэй нийцсэн “Жендэр ба хөгжил” хандлагыг баримталж, 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг Монгол Улсын Их Хурал баталсан юм. Хуулийн хэрэгжилтийг дэмжих хүрээнд 2 үндэсний хөтөлбөр, 1 стратеги төлөвлөгөө, мөн 14 салбар, нийслэл, 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт жендэрийн тусгайлсан хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.

Монгол Улсын “Алсын хараа-2050” хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүг багасгах, хөдөлмөрийн хүрэн дэх ялгаварлан гадуурхалтыг бууруулах, улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх, бүх нийтэд жендэрийн боловсрол олгох тогтолцоог хөгжүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний бүтэц тогтолцоог бэхжүүлж, хамтын ажиллагааг сайжруулах зэргээр жендэрийн тэгш бус байдлыг арилгаж, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг төрийн бодлого төлөвлөлтөд нэвтрүүлж, хүн, нийгэм, засаглалын хөгжлийг тогтвортой дэмжихийг зорьж байна.

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал ирж байгаа энэ орчин цагт эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь, эмэгтэйчүүдийн хөдөлмөр

эрхлэлтийн хэтийн төлөвөө тодорхойлох зайлшгүй шаардлагатай байгаа ба түүнд Төр засгаас хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, бодлогоор дэмжих, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх нь чухал байгаа юм. Монгол Улсын Их Хурал, Нийгмийн бодлогын байнгын хорооны зүгээс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хууль эрх зүйн орчинд тодорхой зохицуулалтыг тусгасан. 2021.07.02-ны өдөр баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад Ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийллийг хориглож, жирэмсэн болон бага насны хүүхэдтэй ажилтанд хөдөлмөр эрхлэх уян хатан, хөнгөвчилсэн нөхцөлийг тусгасан.

Батлагдсан хууль, бодлого хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх, үр нөлөөг нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалын хувьд үнэлэх практик туршлагыг бэхжүүлэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагаа туйлын чухал болохыг харгалзан Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Жендэрийн үндэсний хорооноос “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө” (2022-2031) баталлаа.

Тус стратеги төлөвлөгөөнд бодлого төлөвлөлтийг жендэрийн судалгаа, мэдлэгт суурилуулах, хөгжлийн санхүүжилтэд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нэвтрүүлж үр ашиг, үр дүнг нь нэмэгдүүлэх, ажил эрхлэлт болон мэргэжилтэн бэлдэх хүрээнд хүйсийн зохистой харьцааг хангах тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, соёл урлаг, цахим хөгжил зэрэг бүх салбар, засаг захиргааны анхан шатны нэгж болон хувийн хэвшлийн бодлого үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх, улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг төрийн албаны хууль тогтоомжоор тогтоох зэрэг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, хөгжлийн бодлого төлөвлөгөөг бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх, Монгол Улсын хөгжил дэвшлийн чанартай, хурдацтай, тогтвортой байдлыг баталгаажуулах бодлогын шийдлүүдийг тусгалаа.

Түүнчлэн дэлхий дахинд нүүрлэсэн Ковид-19 цар тахал болон уур амьсгалын өөрчлөлтийн жендэрийн эрх тэгш байдалд үзүүлж буй нөлөөллийг судлах, түүнийг даван туулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, иргэний нийгмийн оролцоо, түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлж, орон нутагт, засаг захиргааны анхдагч нэгжид хүрэх төрийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэхэд тус салбар дундын стратеги төлөвлөгөө бодит үр дүн үзүүлнэ.

Өнөөгийн байдал тулгамдсан асуудал

Эрх зүйн орчны хувьд дэвшилтэт байгаа хэдий ч нийгэмд тогтсон жендэрийн хэвшмэл ойлголт, тэдгээрийг дэмжсэн бүтэц, тогтолцоо, өөрчлөлтийг үл зөвшөөрөх хандлагаас хамаарсан асуудлууд байна.

а/.Нийгэм, соёлын хүрээнд: Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлтүүд гол төлөв ахиц дэвшилтэй байгаа ч боловсролын чанар, агуулга жендэрийн тэгш байдлын үнэт зүйл, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх болон жендэрийн хэвшмэл ойлголт дорвитой өөрчлөгдөөгүй, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээ хөгжөөгүй байна.

Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 9.7 жил байгаа нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр байна. Эрүүл мэндийн статистикийн 2018

оны тайлангаас харахад өвчний улмаас нас барсан эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдээс 1.5 дахин их байгаа нь эрэгтэйчүүд маань эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахгүй байгаатай шууд холбогдож байгааг судалгаа харуулсан. Түүнчлэн стресс менежментийн ойлголт, мэдлэггүйгээс хорт зуршлын хэрэглээ өндөр, эрүүл бус хооллолт, авто тээврийн болон гэнэтийн осолд өртөж буй байдалд жендэрийн талаарх хэвшмэл ойлголт хувь нэмрээ оруулж байгааг мөн олон улсын байгууллага судалсан байна¹.

б/.Улс төрийн хүрээнд: Монгол Улсын хүн амын тал хувь, хөдөлмөрийн насны хүн амын тал хувь, сонгогчийн насны хүн амын тал хувь болсон эмэгтэйчүүд улс төр, шийдвэр гаргах түвшинд томилогдон ажиллах байдал нь 30 хувьд ч хүрэхгүй байна. 1992 оноос хойш УИХ-ын 8 удаагийн сонгуульд нийт 608 гишүүн сонгогдсоноос давхардсан тоогоор 64 нь эмэгтэй гишүүд байна. Хамгийн дээд түүхэн амжилт нь одоогийн парламентад буй 13 эмэгтэй гишүүн буюу 17.1 хувь болж байна.

в/.Эдийн засгийн хүрээнд: Улс орны, аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн бодлого төлөвлөлтийн шатанд жендэрийн дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцох, нөлөөлж залруулах чадвар, нөөц байхгүйгээс жендэрийн тэгш бус байдлын суурь шалтгааныг арилгахад ахиц гаргаж чадаагүй нь нийгэм дэх тэгш бус байдлыг, түүний дотор хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн зөрүүг ихэсгэсээр байна. Эдийн засаг төрөлжихгүй, ялангуяа хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбарт зохистой ажлын байр хангалттай бий болохгүй, жижиг дунд, бичил бизнесийн орчин сайжрахгүй байгаагаас өнөөдөр хот, хөдөөгийн орлого багатай эмэгтэй, эрэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх боломж, сонголт нэмэгдэхгүй байна. Энэ нь орлогын ялгаа гүнзгийрэх нөхцөлийг бүрдүүлж, нийгэм дэх зөрчил, стресс, түүний дотор жендэрт суурилсан хүчирхийлэл /гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамт, хүчин, бэлгийн мөлжлөг/ нэмэгдэх суурь шалтгаан болох төлөвтэй байна².

Эдийн засгийн уналт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд илүү нөлөөлж, ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин буурсны зэрэгцээ эмэгтэйчүүдийн цалингийн дундаж эрэгтэйчүүдийнхээс доогуур хэвээр, зөрүү нь багасаагүй, ажилд авахад эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн үүргээр нь ялгаварлан гадуурхах явдал гарсаар, хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн хэвтээ ба босоо ялгарал цаашид үргэлжлэх хандлагатай байна. Залуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх байдал буурч байгаа нь бага насны хүүхдээ асрахтай шууд уялдаатай байна. Тиймээс хөдөлмөрийн насны тал хувь болсон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхэд саад болж буй асуудлыг бүрэн дүүрэн үнэлсэн бодлого, шийдвэр дутагдаж байна.

Шийдэл:

- Баталсан хууль, тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд шаардлагатай төсөв, санхүүжилтийг Улсын төсөвт шат дараатай тусгах
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 99 дүгээр захирамжаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г баталсан билээ. Энэ хүрээнд төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлсэн бөгөөд мөн түүнчлэн Жендэрийн үндэсний хорооны

¹ Жендэрийн үндэсний хороо, Үндэсний статистикийн хороо, Суурь судалгааны тайлан, (УБ, 2020);

² Жендэрийн үндэсний хороо, Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж, (УБ, 2020).

хуралдаанаар тус асуудлаар цаашид авах арга хэмжээний талаар холбогдох баримт бичгийг боловсруулж, батлуулах ажлыг Хороонд үүрэг болголоо. /2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоол/

- Монгол Улсын Ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хорооны ээлжит хуралдаанаар 2023 оныг “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, Авлигын эсрэг эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих” жил болгон зарласан билээ. Жендэрийн үндэсний хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх 1 зорилго болгож тусгасан. Энэ хүрээнд тухайлбал Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо төлөөллийг нэмэгдүүлэх чиглэлээр Улс төрийн нам, түүний санхүүжилтийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн орчныг сайжруулах, улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг нэвтрүүлэх, Улс төрийн намуудаас ирүүлсэн ЖЭТБхТхуульд заасан тайлан мэдээнд жендэрийн дүн шинжилгээ хийх, УИХ-ын эмэгтэй гишүүдийн бүлгийн үйл ажиллагаа, гишүүдээс санаачилсан хууль /2012-2022/-д жендэрийн дүн шинжилгээ, мониторинг хийхээр төлөвлөө.
- Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байна. Энэхүү хуулийг боловсруулах нь хүн амын томоохон бүлэг болох эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлж, эрх зүйн орчин бүрдүүлэх замаар тэднийг дэмжих, улмаар эдийн засгийн салбар дахь хүйсийн тэгш байдлыг хангах, улмаар нийгмийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгах үндэслэл болох юм.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгаснаар нийгмийн харилцааны бүхий л салбарт хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах нь тогтвортой хөгжлийн суурь болдог гэж үздэг. Энэ хуулийн төслийг боловсруулах болсон хууль зүйн үндэслэл нь, Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцын 11 дүгээр зүйлийн, Эрэгтэй эмэгтэйчүүдэд ажлын хувьд тэгш хандах ажлын чанарыг адил үнэлүүлэх, банкны зээл авах, үл хөдлөх хөрөнгө барьцаалах болон бусад хэлбэрээр санхүүгийн зээл авах эрхээр хангах тухай олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх юм. Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эмэгтэйчүүдэд нийгмийн амьдралын бүх хүрээнд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах, тэгш боломжоор хангагдах боломж бүрдүүлэх зорилтууд хангагдана. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн хуулийн ач холбогдол нь хүйсээр ангилсан нэгдсэн мэдээллийн сан бий болж, түүнд суурилсан бодлого хөтөлбөр хэрэгжинэ. Бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх замаар санхүүгийн хөшүүргүүд зорилтот бүлэгтээ хүрнэ. Олон улсын санхүүгийн төрөлжсөн үйлчилгээнүүдэд эмэгтэй бизнес эрхлэгчид хамрагдах боломж бүрдэнэ. Банк санхүүгийн байгууллагууд эмэгтэй бизнес эрхлэгчдэд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх хөшүүрэг болно. Жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт хэрэгжинэ. Ижил төрлийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хоршоолон, хамтарч ажиллах боломжууд нэмэгдэнэ. Өнөөдөр дэлхийн 35 орон эмэгтэй бизнес эрхлэгч хэн бэ гэдгийг тодорхойлсон хуультай байна. Азийн хөгжлийн банкны судалгаагаар, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэнээр дотоодын нийт бүтээгдэхүүнээ 16.1 хувиар өсгөх

боломжтой байдаг үзүүлэлт гарсан байна. Тэгвэл микро буюу гэр бүл түвшинд жендэрийн эрх тэгш байдал хангагдсанаар гэр бүлийн хүчирхийлэл буурна гэж 2020 онд 100 гаруй аж ахуйн нэгжүүдийн дунд хийсэн судалгаанд оролцогчдын 87 хувь нь үзсэн гэдгийг онцоллоо.

Тогтвортой хөгжил, Жендэрийн эрх тэгш байдал чуулга уулзалтад оролцож буй хүндэт зочид, төлөөлөгчидөө,

Улсын Их Хурал, Нийгмийн бодлогын байнгын хорооны зүгээс жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах хүрээнд Улсын Их Хурлаас баталж буй хууль, бодлогын шийдвэртээ хүйсийн эрх тэгш байх зарчмыг тогтмол баримталж байгааг Та бүхэнд дахин хэлье.

Анхаарал хандуулсан та бүхэнд талархлаа илэрхийлье.